

## 12

**Гадаад худалдааг зохицуулах нь**

Б.Батбямба

Улс орнуудын дэлхийн эдийн засагт болон тодорхой барааны зах зээлүүдэд злэх байрь суурь харилцан адилгүй байдаг. Олон улсын худалдаанд оролцогч орон бүр өөрсдийн ашиг сонирхолыг хангах үүднээс бие даасан тоддорхой үйл ажиллагаа явуулхыг хичээдэг бөгөөд өөрөөр хэлбэл энэ чиглэлээр тодорхой бодлого хэрэгжүүлнэ гэсэн үг. Энэхүү бодлого нь үндэсний ашиг сонирхол, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол нөхцөл болдог.

Гадаад худалдааны бодлого гэдэгт бусад улсуудтай хийх худалдаанд тодорхой зорилго чиглэл баримталж оролцохыг ойлгоно. Энэ бодлогод 2 үндсэн чиглэл байдаг.

1. Чөлөөт худалдааны бодлого. Улсын зүгээс гадаад худалдаанд нөлөөлөх байдлаас аль болохоор зайлсхийх хэрэгтэй бөгөөд зах зээлийг өөрийнх нь хуулиар зохицуулах чиглэл баримтлана гэсэн үг юм. Үүнийг өөрийн орны пүүс, компаниудад тодорхой хэмжээний чөлөөт байдал олгох талаар бусад улс орнуудтай гэрээ хэлцээр байгуулах зэргээр хэрэгжүүлдэг.

2. Протекционист бодлого. Энэ нь үндэсний эдийн засгийг гадаадын өрсөлдөгчидөөс хамгаалхад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Зах зээлийн чөлөөт хөдөлгөөнийг хориглодог. Дэлхийн зах зээл дээрх эдийн засгийн боломж, өрсөлдөх чадвар зэргээрээ улс орнууд харилцан адилгүй байдаг учраас чөлөөт хөдөлгөөн зарим хөгжил буурай оронд ашиг багатай байх тохиолдол цөөнгүй.

Гадаад худалдааны бодлогын үндсэн зорилго нь: тухайн орны олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох байдлыг өөрчлөх, нэмэгдүүлэх, ашигтай болгох; кспорт, импортын хэмжээг өөрчлөх; гадаад худалдааны бүтцыг өөрчлөх; улс орныг хэрэгцээт шаардлагатай нөөцөөр хангах (түүхий эд, эрчим хүч г.м); экспорт импортын барааны үнийн зөрүүг багасгах зэрэгт оршдог.

Өнөө үед гадаад худалдааны зохицуулалтыг үндэсний болон олон улсын түвшинд явуулдаг.



Үндэсний хэмжээнд гадаад худалдааг зохицуулахдаа эдийн засгийн болон засаг захиргааны арга, хэрэгсэлүүдийг ашигладаг.

**Эдийн засгийн арга** гэдэгт татвар ногдуулалт (гаалийн татвар, тариф, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар г.м), засгийн газрын санхүүжүүлэлт, зэрэг багтана. Хэрэгслүүд: *Гаалийн тариф*-гаалийн татвар ногдох бараа таваарын нэрс болон оногдох татварын хувь хэмжээг системтэйгээр байрлуулсан жагсаалт.

*Гаалийн татвар* гэдэг нь улсын хилээр нэвтэрч буй бараа, өмч хөрөнгө болон үнэт зүйлсээс гаалийн байгууллагаар дамжуулан улсад хураан авч буй мөнгөн хураамж юм.

Барааны хөдөлгөөний чиглэлээс хамаарч экспорт, импорт болон транзит барааны гаалийн татвар гэж байдаг.

Хамгын ихээр хэрэглэгддэг татвар бол импортийн татвар байдаг. Үндэсний үйлдвэрлэгчид, дотоодын үнийн түвшинг хамгаалах түүнчлэн санхүүгийн болон улс төрийн зорилгоор импортын татварыг тогтоодог. Экспортийн татварыг харьцангуй бага хэрэглэгддэг ба эх орны үйлдвэрийн бүтээгдхүүнийг гадаад зах зээлд гаргах, улмаар тодорхой валютын орлого олох боломжыг харгалзан үзэж тогтоодог. Ихэвчлэн ямар нэгэн бараа бүтээгдхүүний хомсдол дотоодод үүссэн болон санхүүгийн зорилгоор хэрэглэдэг. Транзитийн татвар маш ховор хэрэглэгддэг.

Татварын хувь хэмжээг адвалорный буюу барааны үнийн дүнгээс хувиар, специфический буюу тусгай (барааны нэгж буюу хэмжигдхүүнд), комбинированный буюу хосолсон г.м-р тогтоодог.

Өнөө үед ихэнх улс оронд барааг гаалийн зорилгоор үнэлэхдээ ГАТТ-ийн хүрээнд батлагдсан хэлэлцээрүүдийн дагуу гаалийн үнэлгээны арга, аргачлалыг хэрэглэж байгаа. Одоогоор гаалийн татварын дэлхийн дундаж хэмжээ ойролцоогоор 6% байгаа.

Ихэнх улс орон гаалийн татварын хамгийн өндөр хувь хэмжээгээ гаалийн тарифын хуулиндаа шууд заасан байдаг. Харин хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрээр тохиролцсон гаалийн татварын хөнгөлөлттэй хувь хэмжээ ба тухайн оронд үндэсний нэн тааламжтай нөхцөл үзүүлдэг улсын гарал үүсэл бүхий бараанд гаалийн татварын нэн тааламжтай буюу преференциальный хувь хэмжээг хэрэглэж болох тухай эрх зүйн орчинг бүрдүүлсэн байдаг.

Нэмэгдэл татварууд болох захиргааны, гаалийн, улсын тэмдэгтийн, хилийн хураамж зэрэг нь бас гадаад худалдааг зохицуулах хэрэгсэл болдог. Эдгээрийг гаалийн татвар хэрэглэх нь улс төрийн хувьд тухайн оронд ашиггүй тохиолдолд хэрэглэдэг. Түүнчлэн Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнууд гаалийн татвараа нэмэхгүй байх талаар тодорхой үүрэг хүлээсэн байдагтай холбоотой. Өндөр хөгжилтэй орнуудад импортийн бараанд дотоодын бараатай ойролцоо хувь, хэмжээгээр татвар ногдуулдаг. Тэнцүүлэх татвар нь үнийн түвшинг ойртуулах зорилготой.

Экспортын санхүүжилт гэдэгт ашгийг нь бууруулахгүйгээр гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх зорилгоор дотоодын пүүс компаниудад улсын зүгээс санхүүжилт олгохыг ойлгодог.



**Засаг захиргааны арга хэрэгсэл** гэдэг нь үндэсний үйлдвэрлэлийн тодорхой салбарыг хамгаалах зорилгоор импортод шууд хязгаарлалт тогтоох үйл ажиллагааг ойлгоно. Үүнд квот (контингент), лиценз зэрэг орохоос гадна гадаад худалдааг хориглох шинж чанаргүй гаалийн формальность, техник, чанарын болон хорио цээрийн стандарт нормын шаардлагууд, барааны баглаа боодол, тэмдгэлгээ шаардах зэрэг зүйлүүд орно.

**Квот** гэдэгт тодорхой хугацаанд экспорт, импортын бараанд үнийн дүнгээр болон тоон хязгаарлалт тогтоож буйг ойлгоно. Квотын хэмжээг тэгтэй тэнцүүлбэл эмбарго гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл экспорт, импортыг хориглоно гэсэн үг. Квотыг заримдаа боломжит экспорт, импортын хэмжээнээс илүүгээр тогтоодог. Энэ нь хориг биш харин ямар нэгэн бараа бүтээгдхүүний урсгалд төрөөс хяналт тавьж байгаа хэрэг болдог. Экспортод квотыг маш ховор хэрэглэдэг ба дотоодод тухайн барааны эрс хомсдол бий болсон үед болон улс төрийн зорилгоор хэрэглэдэг. Импортын тухайд квотыг гадаадын хүчтэй өрсөлдөгчдөөс үндэсний үйлдвэрлэгчдыг хамгаалах, ажилгүйдлыг багасгах, төлбөрийн балансыг нэмэгдүүлэх, барааны урсгалд хаалт тавих зорилгоор хэрэглэдэг. Квотыг голчлон лицензын хэлбэрээр тогтоодог ба энэ экспорт, импортын зөвшөөрөл болдог. Эрх бүхий төрийн захиргааны байгууллагуудаар дамжуулан олгодог.

Эрүүл мэнд хүрээлэн байгаа орчныг хамгаалах асуудал олон улсын худалдааг зохицуулах арга хэрэгсэл болдог ба үүнийг шууд бус арга замаар хэрэгжүүлдэг. Чанарын баталгаа, техникийн шаардлага г.м нь тухайн бараатай холбоотой зардлыг нэмгэдүүлдэг.

Валютын төлбөр хийхэд зарим оронд зөвшөөрөл шаардах явдал байдаг. Энэ гадаад худалдааны хориг саад болдог.

Нэгдсэн гадаад худалдааны бодлого явуулах зэрэг тодорхой зорилгоор улс орнууд нэгдэх явдал байдаг. Түүнчлэн өөр хоорондоо хийж буй худалдаандаа хэрэглэх гаалийн татварыг багасгахаар тохиролцох нь бий.

Гаалийн татварыг харилцан багасгасны дараагаар тэдгээрийн гуравдагч орнуудтай хийх худалдаанд хэргэлэх гаалийн татварын хувь хэмжээ нь хуучнаар хадгалагдан үлдэж байвал чөлөөт худалдааны бүс, харин гуравдагч орнуудад нэгдсэн гаалийн тариф хэрэглэхээр давхар тохиролцсон тохиолдолд дээрхи орнуудын хооронд гаалийн холбоо бий болсныг илтгэнэ.

Эдгээр нь гадаад худалдааг олон улсын түвшинд зохицуулж буй хамгийн энгийн хэлбэрүүд юм. ОУ-н худалдааг ерөнхийд нь зохицуулж байдаг байнгын үйл ажиллагаа бүхий олон улсын хэмжээний олон талт худалдаа-эдийн засгийн байгууллагууд байгаа бөгөөд тэдгээрийн тоо 300 орчим гэсэн тооцоо бий. Дэлхийн худалдаа бүрэлдэн бий болоход гол үүргийг худалдаа-эдийн засгийн байгууллагууд гүйцэтгэдэг. Тэдгээрээс хамгын өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг нь Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) юм. ДХБ нь Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн (ТХЕХ) байгууллагын суурин дээр байгуулагдсан бөгөөд ТХЕХ (GATT) гэдэг нь оролцогч улс орнуудын хоорондох худалдааны харилцаанд удирдлага болгох хууль, эрх зүйн хэм хэмжээ, дүрэм журам, зарчмыг агуулсан олон талт гэрээ юм. Уг хэлэлцээр 1947.10.30-нд Женевт батлагдсан бөгөөд 1948.1.1 нээс өөрийн оролцогч 23 улсын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ гэрээний үндсэн дээр байгуулагдсан



байгууллага болох GATT нь 40 гаруй жил ОУ-н хэмжээнд худалдааны үйл ажиллагааг зохицуулах үүргийг биелүүлж ирсэн ба төв байгууллага нь байсан. Өөрийн гишүүн орны хүрээнд гэрээгээр тохиролцсон аливаа асуудлын хүрээнд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, ОУ-н худалдааны харилцааны эрх зүйн байдалтай холбоотой олон талт худалдааны хэлэцээрүүдыг зохион байгуулах, маргаантай асуудлуудыг авч үзэх, дэлхийн худалдааны чухал шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулж байв.

GATT-д хамаарах асуудлын гол онцлого нь хувьсан өөрчлөгдөж буй гадаад эдийн засгийн харилцаанд зохицуулан тус байгууллагын бүтэц, хэлэлцээрийн хууль эрх зүйн хэм хэмжээнүүдийг өөрчлөх боломжтой байсанд оршино. Чухам үүнд л энэ хэлэлцээрийн үндсэн дээр ДХБ бий болсон шалтгаан байгаа юм.

GATT нь 1994 оныг хүртэл худалдааны раунд хэмээн нэрлэгдсэн нийт 8 үе шатыг дамжсан ба эдгээр үе шатуудад гишүүн орнуудын хүрээнд гадаад худалдааны тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах талаар тодорхой зорилтууд тавьж ажиллаж байсан болно.

ДХБ-н үйл ажиллагааны үндсэн зорилго худалдааны дүрэм журмыг шинэчлэх замаар бараа үйлчилгээний худалдааг либералчлахад оршино. Энэхүү зорилгоо хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бодит орлого, эрэлтийг дээшлүүлэх, түүхий эд материалын ашиглалтыг үр ашигтай болгох, үйлдвэрлэл, худалдааг өргөжүүлэх үүднээс олон улсын худалдаан дахь гаалийн болон бусад элдэв хэлбэрийн хориг саадыг арилгах замаар хэрэгжүүлдэг.

ДХБ-ын хууль зүйн үндэс нь 1995.01.01-нээс үйлчилж эхэлсэн ТХЕХ (GATT) болон ҮХЕХ (GATS), ОӨЭХХ (TRIPS) зэрэг хэлэлцээрүүд юм. Эдгээрт гишүүн улс орнуудад адил хүчинтэй олон арван гэрээ, хэлэлцээр, протокол, шийдвэрүүд багтдаг. ДХБ-н зарим бичиг баримтууд нь ДХБ-н бүх бичиг баримтуудын дотор хүчинтэй хэвээр байгаа ТХЕХ-н хэм хэмжээнүүдыг тодотгож нэмж байдаг. Орших хаяг нь Женев (Швейцар) бөгөөд 150 илүү улс орныг нэгтгэдэг бөгөөд ОХУ зэрэг орнууд элсэх талаар гэрээ хэлэлцээр эрчимтэй хийсээр байгаа билээ.

Монгол улс ДХБ-ын гишүүн болсноор (1997 онд) гадаад худалдааны салбарт хэрэгжүүлж буй бодлого хумигдах биш харин хөгжиж буй орнуудад олгодог аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг зөвөөр, бүрэн эдлэх боломж нээгдсэн ба улс эх орны эрх ашигтай холбоотой асуудлуудаар олон улсын эрх зүйн хамгаалаланд орж улмаар бусад улс орнуудтай эдийн засгийн хувьд эрх тэгш харилцах өргөн бололцоотой болсон юм.